

## МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 25/2

Улаанбаатар хот

Мөнгөний бодлогын хороо (МБХ) 2025 оны 3 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд хуралдаж, хуралдааныг Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн удирдав. Хуралдааны эхний өдөр мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засаг, банкны салбарын өнөөгийн байдлын талаар Монголбанкны хариуцсан газрууд танилцууллаа. Хуралдааны дараагийн өдөр эдийн засгийн цаашдын төлөв, бодлогын саналыг Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Хурлын эхний өдөр Санхүүгийн зах зээлийн газар (СЗЗГ)-аас мөнгөний захад гарсан өөрчлөлт, мөнгөний бодлогын хэрэгжилтийн талаар танилцууллаа. Энэ оны эхний 2 сарын байдлаар гадаад валютын орох урсгал өмнөх оны мөн үеэс 696 сая ам.доллаароор буурч, гарах урсгал 234 сая ам.доллаароор нэмэгджээ. Орох урсгал ийнхүү буурахад нүүрсний хилийн үнэ буурч, нүүрсний экспортын орлого саарсан нь голлон нөлөөлсөн бол машин, механизмын тоног төхөөрөмж, шатахуун, тосолгооны материалын импорт өсөж, хувийн байгууллагуудын гадагш хийж буй төлбөр нэмэгдсэнээр гарах урсгал өмнөх оноос нэмэгдсэн байна. Улмаар гадаад валютын цэвэр урсгал оны эхнээс 538 сая ам.долларын алдагдалтай гарч, гадаад валютын улсын нөөц 2 дугаар сарын байдлаар 4.8 тэрбум ам.долларт хүрсэн байна. Түүнчлэн, Засгийн газрын цэвэр зээл, гадаад цэвэр актив, заавал байлгах нөөцийн хэмжээ нэмэгдсэнээс үүдэн ТБҮЦ-ны үлдэгдэл оны эхнээс 3.1 их наяд төгрөгөөр буюу 26.7 хувиар буурч, энэ оны 2 дугаар сарын байдлаар 8.5 их наяд төгрөгт хүрэв. Банк хоорондын захын арилжаа, хөтөлбөрийн зээлийн санхүүжилт, валютын ханшийн өөрчлөлтийн талаар үргэлжлүүлэн танилцуулав.

Хурлын дараагийн хэсэгт Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (ББӨБГ)-аас банкны салбарын өнөөгийн байдлын талаар танилцууллаа. Банкны системийн нийт актив 2024 онд өмнөх оноос 14.4 их наяд төгрөгөөр буюу 25.4 хувиар өсөж, 71.1 их наяд төгрөгт хүрч нэмэгдэхэд зээлийн өсөлт голлон нөлөөлөв. Банкны системийн нийт пассив 64.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.9 хувиар буюу 13.2 их наяд төгрөгөөр өссөн ба үүнийг хадгаламж болон банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт голлон бүрдүүлсэн байна. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 онд 36.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 35.2 хувиар буюу 9.6 их наяд төгрөгөөр өссөн ба өсөлтийн дийлэнх хэсгийг иргэдийн зээл бүрдүүлсэн хэвээр байна. Гэсэн хэдий ч 2023 онд бууралттай байсан уул уурхайн салбарын зээл 2024 онд өмнөх оноос 68.8 хувиар буюу 998.2 тэрбум төгрөгөөр өссөн нь уул уурхайн салбарын санхүүжилт сэргэснийг илтгэж байгааг танилцууллаа. Банкны системийн чанаргүй болон анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх харьцаа 2024 онд харгалзан 4.4 хувь, 3.4 хувьд хүрсэн нь 2015 оноос хойших хамгийн бага үзүүлэлт болсон байна.

Хурлын сүүлийн өдөр Мөнгөний бодлогын газар (МБГ)-аас бодлогын саналыг эдийн засгийн суурь төсөөлөл, түүнд ашигласан таамаглалт нөхцөлүүд, хувилбар төсөөллүүдэд үндэслэн танилцууллаа.

Инфляц 2025 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 9.6 хувь, Улаанбаатар хотод 9.7 хувьд хүрч өмнөх сараас нэмэгдлээ. Үүнд, цахилгааны үнийн өсөлт, үүний дам нөлөө болон эдийн засгийн идэвхжил, дотоод эрэлт, цалингийн өсөлтийг дагаад үйлчилгээ, түрээс,

импортын барааны үнэ хүлээлтээс өндөр өссөн нь голлон нөлөөлөв. Ийнхүү эрэлтийн болон зардлын шалтгаантай үнийн дарамт хүлээлтээс нэмэгдсэн, нийтийн тээврийн үнэ 2-р сард өссөн, төгрөгийн ханш өмнөх төсөөллөөс суларч, импортын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөх зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр энэ оны инфляцын төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлснийг танилцуулав. Ийнхүү инфляц энэ онд зорилтын дээд хязгаарыг давж, ирэх онд эдийн засгийн идэвхжил саарч, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлтийн суурь нөлөө арилснаар оны сүүлийн хагасаас зорилтын интервалд орж тогтворжих төлөвтэй байна. Инфляцын өсөлтөд төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ багагүй жин дарж байгаа бөгөөд орон сууцны ус суваг, дулаан, халуун ус, автобусны үнэ нэмэгдсэнээр энэ оны 2-3 дугаар улиралд инфляцад нийт 3-3.1 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байгааг дурдлаа.

Эдийн засаг 2024 онд урьдчилсан гүйцэтгэлээр 4.9 хувиар өслөө. Нүүрсний олборлолт 100 сая тоннд хүрч, Оюу толгойн зэс, алтны үйлдвэрлэл нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлт 10.8 хувьд хүрсэн байна. Түүнчлэн, дотоод эдийн засгийн идэвхжил, импортын өсөлтийг даган татварын орлого бүрдүүлэлт сайн байж, бүтээгдэхүүний цэвэр татвар нэмэгдсэнээр өсөлтийг 2.0 нэгж хувиар дэмжлээ. Харин өнгөрсөн өвлийн цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас хөдөө аж ахуйн салбар 28.7 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтөд 3.6 нэгж хувийн сааруулах нөлөөг үзүүлсэн байна. Цаашлаад энэ онд эдийн засгийн өсөлт 7.6 хувь буюу өмнөх төсөөллийн орчимд байхаар байна. Үүнд, Оюу толгойн зэсийн үйлдвэрлэл нэмэгдэж байгаа нь уул уурхайн салбарыг тэтгэх, цаг агаарын нөхцөл өнгөрсөн жилтэй харьцуулахад таатай байж, мал аж ахуйн салбар сэргэх, том төслүүд хэрэгжиж барилгын салбарт эергээр нөлөөлөхөөр байгаа нь эдийн засгийн өсөлтийг тэтгэх гол хүчин зүйлс болж байна. Ирэх онд голлох эрдэс бүтээгдэхүүний олборлолт 2025 оны түвшинд хадгалагдаж, Оюу толгойн алтны агууламж буурах ч цэвэр зэсийн хэмжээ нэмэгдэхээс гадна хөрөнгө оруулалтууд нэмэгдэх, төслийн бүтээн байгуулалтын ажлууд үргэлжлэх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих бол 2027 оноос гадаад эрэлт саарах, худалдааны нөхцөл муудах, бүтээн байгуулалтын ажлууд дуусаж, эдийн засгийн өсөлтийг сааруулахаар байна.

Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2024 онд 776 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, тэнцвэржүүлсэн орлогын гүйцэтгэл 96.3 хувь, зардлын гүйцэтгэл 90.4 хувьтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 1.1 их наяд төгрөгөөр (39 хувиар) буурч, 1.7 их наяд төгрөгт хүрсэн нь ОАТ<sup>1</sup>, НӨАТ<sup>2</sup>, АМНАТ<sup>3</sup>-ийн орлогын бууралтаас шалтгаалав. Төсвийн зардал 2.2 их наяд төгрөгт хүрч, улмаар тэнцвэржүүлсэн тэнцэл 493 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна. Энэ онд төсвийн зардал тэлж, төсвийн төлөв сулрахаар байгаа бол ирэх онд бага зэрэг чангарах төлөвтэй байгааг танилцууллаа.

Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 1 дүгээр сард 11.6 хувьд хүрч буурахад төлбөрийн тэнцлийн алдагдлаас шалтгаалан гадаад цэвэр активын өсөлт саарсан нь голлон нөлөөлөхөөр байна. Нийт зээлийн өсөлт 30.6 хувьд хүрч, өндөр түвшинд хадгалагдсан хэвээр байна. Үүнд, эдийн засгийн идэвхжил, хөнгөлөлттэй зээлийн нөлөөгөөр бизнесийн зээлийн өсөлт 33.9 хувьд хүрч эрчимжсэн нь голлох нөлөөг үзүүлсэн бол хэрэглээ, хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт алгуур саарч 31.2 хувьд хүрчээ. Цаашид гадаад валютын цэвэр орох урсгал саарч, банкны системийн зээл олгох боломжит эх

---

<sup>1</sup> Орлогын албан татвар

<sup>2</sup> Нэмэгдсэн өртгийн албан татвар

<sup>3</sup> Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

үүсвэр буурснаар зээлийн өсөлт саарах хүлээлттэй байна. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт ирэх онуудад төлбөрийн тэнцэл болон зээлийн өсөлтийн төсөөлөлтэй уялдан нам түвшинд хадгалагдахаар байна.

Гадаад орчин, төлбөрийн тэнцлийн нөхцөл байдлыг авч үзвэл, АНУ-ын засаг захиргаанаас хэрэгжүүлэхээр зорьж буй татварын бодлоготой холбоотойгоор гадаад орчны эрсдэл, тодорхой бус байдал нэмэгдлээ. БНХАУ-ын үл хөдлөх салбарын хямрал үргэлжилж, дотоод эрэлт сул байгаагаас эдийн засгийн өсөлт ирэх онуудад саарах, нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байгааг танилцуулав. Гадаад худалдааны гүйцэтгэлийн хувьд, энэ оны 1 дүгээр сард экспортын орлого өмнөх оны мөн үеэс 23 хувиар буурахад нүүрсний орлого буурсан нь гол нөлөөг үзүүлжээ. Харин хөрөнгө оруулалтын болон түргэн эдэлгээт бүтээгдэхүүний импорт буурснаар импортын өсөлт саарч, 1 дүгээр сард 4 хувьд хүрлээ. Төлбөрийн тэнцэл 2024 онд 622 сая ам.долларын ашигтай гарсан ба алт, зэсийн үнэ нэмэгдэж, нүүрсний экспортын биет хэмжээ түүхэн дээд түвшинд хүрсэн, Нийслэл болон банкуудын гадаад зах зээлд шинээр гаргасан бондын нөлөөгөөр санхүүгийн дансны ашиг өссөн нь голлон нөлөөлөв. Харин энэ онд нүүрсний үнэ буурах, улмаар экспортын орлого багасах нь төлбөрийн тэнцлийн төлөвийг өмнөхөөс муутгахаар байгааг танилцуулав. Улмаар гадаад худалдаа, урсгал тэнцэлтэй холбоотойгоор гадаад секторын эмзэг байдал нэмэгдэж байгааг онцоллоо.

Үргэлжлүүлээд банкны систем дэх хэрэглээ болон тэтгэврийн зээлийн нөхцөл байдлыг танилцуулав. Банкны системийн хэрэглээний зээлийн үлдэгдэл 2024 оны эцсийн байдлаар 11.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 35.5 хувиар өсжээ. Үүний 23.7 нэгж хувийг цалингийн зээл, 5.3 нэгж хувийг тэтгэврийн зээл тус тус бүрдүүлсэн байна. Тооцооллоор дундаж өрхийн хувьд амьжиргааны суурь зардлаа хангахын тулд сарын орлогынхоо 48 хувиас багагүй хэсгийг хэрэглээндээ зарцуулах шаардлагатай байхаар байна. Гэтэл зээлдэгчид ӨОХ-ны дээд хязгаарт буюу 55 хувьд тулгаж зээл авах хандлагатай байгаа нь тухайн өрхийн хувьд амьжиргааны суурь зардлаа хангаж чадахгүйд хүрэх, өрийн дарамт өндөр байх нөхцөлийг үүсгэж байна. Цаашлаад тэтгэврийн зээлийн нөхцөл байдлыг авч үзвэл, нийт тэтгэвэр авагч иргэдийн талаас илүү буюу 53.2 хувь нь тэтгэврийн зээлтэй, эдгээр иргэдийн дундаж ӨОХ 84 хувьтай байна. Түүнчлэн, тэтгэврийн зээлдэгчдийн 82.3 хувь нь хамгийн багадаа нэг удаа зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, нэмэлтээр зээл авч байгаа нь дээрх иргэдийн хувьд санхүүгийн хараат бус байдал алдагдсан, нийгмийн баталгаа хангагдахгүй байх нөхцөл үүссэн болохыг танилцууллаа.

Ийнхүү МБГ-аас эдийн засаг, банк, санхүүгийн салбарын нөхцөл байдал, инфляцын цаашдын төлөв, эрсдэлийг харгалзан; i) бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэх, ii) хэрэглээний зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 50 хувьд хүргэх, iii) банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлийн сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэх орлого нь амьжиргааны доод түвшнээс доошгүй байхаар тогтоох саналуудыг дэвшүүллээ. Ингээд гишүүдийн зүгээс дээрх саналуудтай холбоотой асуулт асууж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Нэг гишүүний зүгээс төсвийн зардлын тэлэлт, цалингийн өсөлт, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнийн өсөлт болон эдгээрийн дам нөлөө нь инфляцын дарамтыг нэмэгдүүлж, цаашид инфляц эрчимжих эрсдэлийг үүсгэж байна. Иймд бодлогын хүүг 2 нэгж хувиар өсгөн мөнгөний бодлогын төлөвийг хатууруулж, инфляцыг зорилтот

түвшинд хүргэж тогтворжуулах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлэв. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт зэрэг нь одоогийн суурь төсөөлөлд авч үзсэнээс нэмэгдэх тохиолдолд инфляц, эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх хувилбар тооцооллыг боловсруулж, олон нийтэд нээлттэй мэдээлэх нь зүйтэйг дурдлаа. Өөр нэг гишүүний хувьд бодлогын хүүг 2 нэгж хувиар огцом нэмэгдүүлж болох ч шат дараатайгаар 1, 1 нэгж хувиар өсгөх боломж байгааг сануулав. Харин бусад гишүүдийн зүгээс экспортын түүхий эдүүдийн үнэ буурч, гадаад секторын эмзэг байдал нэмэгдсэн, эрэлт, зардлын шалтгаанаар инфляц өсөж, цаашид хүлээлтээр дамжин эрчимжих эрсдэлтэй энэ үед бодлогын хүүг 2 нэгж хувиар өсгөж, зах зээл дэх инфляцын хүлээлтийг бууруулах нь зүйтэй гэж үзлээ. Ийнхүү гишүүд 100 хувийн саналаар бодлогын хүүг 12 хувьд хүргэх шийдвэрт санал нэгдлээ.

Үүний дараа гишүүд хэрэглээний зээлийн ӨОХ-ны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоох саналыг хэлэлцлээ. Нэг гишүүний зүгээс уг шийдвэр нь зээлээ төлсний дараах иргэдийн орлогыг хүн амын амьжиргааны доод түвшинг хангахад чиглүүлж, өрхийн өрийн дарамтыг бууруулах ач холбогдолтой тул саналыг дэмжихээ илэрхийлэв. Өөр нэг гишүүний зүгээс цалингийн өсөлтөөс шалтгаалан иргэдийн зээл авах боломжит хэмжээ нэмэгдэж байгаа нь хэрэглээний зээл хэт өсөх, цаашлаад төлбөрийн тэнцэл, валютын ханшид дарамт учруулж байгаа тул зээлийн хэт өсөлтийг хязгаарлах нь зүйтэй гэж үзэв. Түүнчлэн, бусад гишүүдийн зүгээс хэрэглээний зээлийн ӨОХ-ны хязгаарыг 50 хувьд хүргэх нь олон улсын туршлагатай нийцтэй бөгөөд тус арга хэмжээ нь банкны системийн зээлийг бизнесийн зээлд чиглүүлж, ажил эрхлэлтийг дэмжих, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах ач холбогдолтойг онцоллоо. Ийнхүү МБХ-ны гишүүд тус саналыг 100 хувийн саналаар дэмжсэн бөгөөд банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагаас мөрдүүлж буй хэрэглээний зээлийн ӨОХ ялгаатай байгаа нь бодлогын үр нөлөөг сулруулах эрсдэлтэй тул энэ тал дээр анхаарахыг санууллаа.

Хэлэлцүүлгийн эцэст тэтгэврийн зээлд зохицуулалт хийх талаар санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлэв. Тэтгэврийн зээлтэй иргэдийн зээлийн төлбөрийн дарамт харьцангуй өндөр, зээлээ төлж дуусахаас өмнө зээлийн гэрээнд өөрчлөлт оруулан нэмж зээл авах хандлагатай байгаа нь тухайн иргэдийн хувьд санхүүгийн хараат бус байдал алдагдаж, зээлийн төлбөрийн хүндрэл үүссэнийг илтгэж байна. Иймээс тус арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж, гишүүд 100 хувийн саналаар дэмжихээ илэрхийллээ. Ийнхүү Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 1 дүгээр улирлын ээлжит хурал өндөрлөв.

## ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 3 дугаар сарын 6, 7-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан үзээд:

1. Бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэх;
2. Банкнаас иргэдэд шинээр олгох болон нөхцөлийг нь өөрчлөх хэрэглээний зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд шинэчлэн тогтоох;
3. Тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд зээлийн сарын төлбөрөө төлсний дараах зээлдэгчийн үлдэх орлого нь хүн амын амьжиргааны доод түвшнээс доошгүй байхаар тогтоох зэрэг шийдвэрийг тус тус гаргалаа.

### Бодлогын саналын шийдвэр

